

**“ҮНЭТ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН ЗЭРЭГЛЭЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ” ҮЗМЭРИЙН ЖАГСААЛТЫН ТӨСӨЛ**

<b>ТӨВ АЙМГИЙН МУЗЕЙ</b>								
Д/д	Үзмэрийн нэр	Хувийн дугаар	Тоо ширхэг	Хэмжээ	УБМС-ийн дугаар РСН (программын)	Судлагдсан сурталчлагдсан байдал	Саналын үндэслэл	СӨҮТ-ийн санал
1	Гүнжийн аяганы ширээ	60-118	1	Өн-35,5 см, ур-50,5 см, өр-38,5 см, 8460 гр	4101ТӨМ0154 7	3. Оюунбилэг (Ph.D), Ж. Наранчимэг нарын “Гүнжийн сүм” судалгааны ажлын ном	Гүнжийн сүм судалгааны номонд дурьдсанаар..., гүнжийн шүүгээ нь улаан чий будагтай, нүүрэн талдаа 4 шургуулгатай, шургуулга бүр гуулин бариултай. Дөрвөн шургуулганы гол хэсэгт 4 хумстай луу ухаж дүрсэлсэн алт шармал суурьтай цүү болон бариултай. Дээд талдаа зургаан углуурганы нүхтэй, цулгүй улаан чий будагтай, эргэн тойрон галт шувуу, бадам цэцгэн хээг цоолборлон сийлбэрлэж алтаар будсан хашлагатай. Хоёр хажуу болон ар талын улаан дэвсгэр дээр галт шувуу, бадам болон мандарваа цэцгийг алтаар уран сайхнаар зурсан. мөн шүүгээний хормойд эргэн тойрон бадам цэцэг цоолборлон сийлж алтадсан байна. Дээрх эд зүйлийг Чингийн үеийн гоо сайхны шүүгээтэй харицуулан үзэхэд энэхүү аяганы ширээ нь гүнжийн гоо сайхны шүүгээ байсан бололтой. Энэхүү гоо сайхны шүүгээ нь дээрээ толь тогтоох суурьтай доод талдаа оо энгэсэг хийх шургуулгатай байх бөгөөд хөх хот дахь гүнжийн ордны болон Чингийн үеийн хатдын өргөөний зохион байгуулалттай харьцуулбал гүнж	Дэмжсэн

							хатдын орны дээд талд байрлуулдаг байжээ.	
2	Бугуйвч	83-1161	1 (хос)	Ур-6,5 см, зу-1,3 см, 80 гр	4101ТӨМ00230	3. Оюунбилэг (Ph.D), Ж. Наранчимэг нарын "Гүнжийн сүм" судалгааны ажлын ном	Гүнжийн сүм судалгааны номонд дурьдсанаар..., энэхүү алт шармал мөнгөн бугуйвчийг 1000 төгрөгөөр музейн үзмэр болгон худалдан авсан байна. Энэхүү алт шармал мөнгөн бугуйвч нь хагас дугуй бөгөөд бугуйн дотор талын хэсэг нь хавтгай, харин бугуйвчны эргэн тойрон цэцэг, навч болон түгжээний хоёр талд өлзий хээг товойлгон цутгасан алт шармал мөнгөн нугас, түгжээтэй болно. Мөн бугуйвчны дотор талд хятад ханз бүхий дардастай юм.	Дэмжсэн
3	Зүү утасны сав (Аяга, цайны сав)	89-1500-2	2	Аяганы амсрын дм-10,7 см, өн-5,5 см, 165 гр, зүү утасны савны өн-7,5 см, дм-7,5 см, 185 гр	4101ТӨМ01548	3. Оюунбилэг (Ph.D), Ж. Наранчимэг нарын "Гүнжийн сүм" судалгааны ажлын ном	Гүнжийн зүү хуруувчны хайрцаг гэдгийг судлан үзэхэд Чингийн үеийн цайны сав болох нь тогтоогдсон бөгөөд энэхүү сав болон аяга нь <i>cloisonne</i> (хуваалт гэсэн франц үг) паалантай байлаа. Өөрөөр хэлбэл эд зүйлийн гадаргуу дээр үнэт металл утсаар загварын дагуу зургийг гаргаж, түүнийг паалангийн зуурмагаар дүүргэж бүтээсэн, чимэглэлийн паалангийн урлаг юм. Мин гүрний үед Юнлигийн хаанчлалын эхэн үед холбогдох <i>cloisonné</i> паалантай эд зүйлс маш ховор байдаг. Манж чин гүрний Энх Амгалан хааны үед Эзэн хааны мэдлийн үйлдвэрүүдийн дунд <i>cloisonné</i> паалангийн олон цех ажиллаж байсан байна.	Дэмжсэн
<b>НИЙТ 3 ДЭСИЙН 4 ШИРХЭГ</b>								